

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны ... сарын
өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Дугаар ...

ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолын дагуу үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалагдсан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний тайлан, Засгийн газрын баталгаа гаргасан үнэт цаасны хөрөнгөөр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тайланг Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийн хамт Улсын Их Хуралд тус тус танилцуулж байхыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолыг 2014 оны дүгээр сарын-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Чиглэл өгөх тухай

Төсвийн тухай хуулийн дагуу Засгийн газар нь Улсын Их Хуралд төсвийн гүйцэтгэлийг тайлагнахдаа зөвхөн хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээг тайлагнах үүрэгтэй бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжин хийгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь улсын төсөвт тусгагддаггүй тул энэхүү төсөл, арга хэмжээг төсвийн гүйцэтгэлд тусган тайлагнах боломжгүй байдаг.

Иймд төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, үнэт цаасны хөрөнгөөр хийгдэж буй төсөл, хөтөлбөрийн ил тод байдлыг сайжруулах, УИХ-д тайлагнадаг болгох зорилгоор Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолын дагуу үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалагдсан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний тайлан, Засгийн газрын баталгаа гаргасан үнэт цаасны төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тайланг Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлтэй хамт Улсын Их Хуралд *танилцуулах* тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.